



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/51

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Архивын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, Үндэсний Архивын Ерөнхий газрын даргын 2003 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 145 дугаар тушаалаар батлагдсан “Шинжлэх ухаан, технологи, зураг төслийн баримтад эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийх ажлын журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Төрийн архивт хадгалагдаж буй 1995 оноос өмнөх Шинжлэх ухаан, технологи, зураг төслийн баримтад эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийгдэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Үүнд:

Ажлын хэсгийн

ахлагч:

Б.Мөнгөнцэцэг

-Архивын тасгийн дарга

Нарийн бичгийн

дарга:

Э.Түвшинтөгс

-Сан хөмрөгийн эрхлэгч

Гишүүдэд:

Б.Мягмарсүрэн

-Архивын тасгийн архивч

Б.Содбилэг

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын материал лаборатори хариуцсан мэргэжилтэн

Э.Хандсүрэн

-Баянхутаг сумын Засаг даргын Тамгын газрын архив, бичиг хэргийн эрхлэгч

2. Шинжлэх ухаан, технологи, зураг төслийн баримтад эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх ажлыг чанартай, шуурхай хийж гүйцэтгэхийг Архивын тасгийн дарга, ажлын хэсгийн ахлагч /Б.Мөнгөнцэцэг/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Л.Бат-Октябрь/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР